ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР**

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
8 дугаар хороо, Ж.Лхагвасүрэнгийн гудамж,
Нийслэлийн засаг захиргааны 5 дугаар байр,
Утас: 32-77-34, Факс: (976-11) 32-01-54,
E-mail: ub@audit.gov.mn; http://www.city.audit.mn

2017.03.24 № 783

танай ____________-ны №____________-т

НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАРТ

Санхүүгийн тайлангийн аудитын гэрчилгээ, аудитыг дуусгавар болгосон тухай тайланг хүргүүлж байна.

Хавсралт: 42 хуудас

ДЭД ДАРГА С.ЭНХБААТАР

D:\2017 on\yavuulsan bichig\TOOT DUGNELT 2017.03.24 NEMG A5.docx

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР**
14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
8 дугаар хороо, Ж.Лхагвасүрэнгийн гудамж,
Нийслэлийн засаг захиргааны 5 дугаар байр,
Утас: 32-77-34, Факс: (976-11) 32-01-54,
E-mail: ub@audit.gov.mn; http://www.city.audit.mn

2017.03.24 № 782

танай ____________-ны №____________-т

НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА Л.ТӨМӨРБААТАР ТАНАА

Аудитын гэрчилгээ

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон, аккруэл сууриар бэлтгэгдсэн, санхүүгийн нэгтгэсэн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1-д заасан бүрэн эрхийн дагуу Нийслэлийн Аудитын газраас аудит хийв.

Нийслэлийн Эрүүл мэндийн газар болон харьяа байгууллагуудын удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Аудитын Олон Улсын Стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Нийслэлийн Аудитын газар аудит хийхдээ Аудитын Олон Улсын Стандарт, түүнд нийцүүлэн Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

1110400320

Үндсэн хөрөнгө бараа материаллын ангиллыг 117 906.4 мянган төгрөгөөр буруу бүртгэсэн, төлбөртэй орлогын 17 155.0 мянган төгрөгийг дутуу тайлагнасан, ур чадвар болон бусад нэмэгдэл, шагнал, урамшууллын 57 463.2 мянган төгрөгийг хавтгайруулан олгосон, өмнөх оны аудитаар үндсэн хөрөнгийг давхардуулан бүртгэсэн зөрчлийг арилгахаар өгсөн албан шаардлага хэрэгжээгүй, анхан шатны бүрдэл дутуу баримтаар 25 434.5 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн, 17 754.5 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, 19 666.4 мянган төгрөгийн бараа материалыг хөрөнгийн тооллогод хамруулаагүй, чанаргүй хийсэн, сонгон шалгаруулалтгүй 161 886.0 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн, зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, иж бүрэн байх, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Бидний хийсэн аудит санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн болно.

**<u>Хязгаарлалттай санал дүгнэлт</u>**

Дээрх алдаа зөрчлийг эс тооцвол Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ОЧИРБАТ

D:\2017 on\yavuulsan bichig\2017.03.24 NEM Gerchilgee.docx

# НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

**Аудитын тайлан**

Хавсралт 1: Менежментийн захидал

Хавсралт 2: Байгууллагаас ирүүлсэн хариу

Хавсралт 3: Аудит хийгдсэн санхүүгийн нэгтэсэн тайлан

Хасвралт 4: Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

**С.Энхбаатар**
Нийслэлийн аудитын газрын дэд дарга
өрөөний утас 327734

**А.Цогбаяр**
Санхүүгийн аудитын III албаны менежер
өрөөний утас: 315558

**Х.Оюунчимэг**
Санхүүгийн аудитын VI багийн ахлах аудитор

**Ц.Батсүх**
Ахлах аудитор

**Д.Нарантуяа**
Аудитор

**Ч.Түвшинсайхан**
Шинжээч

**ТАБ-ын хаяг:** Сүхбаатар дүүрэг, Ж.Лхагвасүрэнгийн гудамж, Нийслэлийн засаг захиргааны V байр

**E mail:** ub@audit.mn

**Вэб:** www.city.audit.mn

## АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
8. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар
9. Шилэн дансны мэдээлэл
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

## Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8.9.2, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2-д заасан Нийслэлийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд НАГ-2017/1/СТА-ТТЗ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн, Төрийн аудитын, Нягтлан бодох бүртгэлийн, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын Олон Улсын Стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн Сангийн яамнаас гаргасан заавар, журам, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилго юм.

Уг газар нь санхүүгийн нэгтгэсэн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тус газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Нийслэлийн аудитын газрын үүрэг юм.

Уг газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитыг 2017 оны 3 дугаар сарын 5-наас 2017 оны 3 дугаар сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн Нийслэлийн Аудитын газрын санхүүгийн аудитын III албаны YI багийн ахлах аудитор Х.Оюунчимэг, ахлах аудитор Ц.Батсүх, аудитор Д.Нарантуяа, шинжээч Ч.Түвшинсайхан нар 2017 оны 3 дугаар сарын 15-наас 3 дугаар сарын 25-ны хооронд хийж гүйцэтгэв.

Аудитын тайлан, гэрчилгээг 2017 оны 3 дугаар сарын 24-нд Нийслэлийн Эрүүл мэндийн газрын удирдлагад хүргүүлэв.

## Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Тус газрын дарга нь Төсвийн, Нягтлан бодох бүртгэлийн, Төрийн болон орон нутгийн өмчийн, Татварын ерөнхий хуулиуд болон холбогдох тогтоол, шийдвэр, журам, зааврын хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хуулинд өөрчлөлт ороогүй байна.

## Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Тус байгууллагын дүрмэнд *"Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагийн хувьд эрүүл мэндийн асуудлаар Монгол Улсын Их хурал, Засгийн газар, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн Засаг дарга болон бусад байгууллагуудаас гаргасан бодлого шийдвэрийг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх, зохицуулах, хэрэгжилтийг хянах, хангах чиг үүрэгтэй ажиллана."* гэж байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 16.1 "*Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна"* гэж заасны дагуу Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга болон түүний харъяа дүүргүүдийн Эрүүл мэндийн нэгдэл, амаржих газрууд, бусад эрүүл мэндийн байгууллагуудын дарга нар нь төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын тайлант хугацааны эрүүл мэндийн статистик тоон мэдээллийг товчлон дурдвал:

- Нийт үзлэгийн тоо 6 787.8 мянга, үүнээс 2,039.7 мянган нь амбулторийн үзлэг өмнөх оноос 0.4 мянгаар нэмэгдсэн, эмнэлэгт хэвтэлт 174.0 мянга байгаа нь өмнөх онтой харьцуулахад 9.6 хувиар нэмэгдэж, нийт нас баралт 9.5 хувиар буурсан, 2016 онд эхийн эндэгдэл 5, нялхсын эндэгдэл 123 бүртгэгдэж, өмнөх оны эхийн эндэгдэл хэвээр, нийт төрөлт 27.9 мянга буюу өмнөх оныхоос 1.1 байгаа нь өмнөх оныхтой харьцуулахад 3.9 хувиар буурсан байна.
- Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан орны дээд хязгаар дотор үйл ажиллагаагаа явуулж, нийт ор хоног өмнөх онтой харьцуулахад 9.4 хувь буюу 97.2 мянгаар, орны эргэлт 6.8 хувиар нэмэгдсэн байна.

Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын 2016 оны үйл ажиллагааг Эрүүл мэндийн сайдын багцаас санхүүжүүлж, санхүүжилтийг нийслэл, дүүргийн төрийн сангаас олгосон байна.

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Эрүүл мэндийн яамны салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2010 онд боловсруулан Эрүүл мэндийн сайдын 2010 оны 138 тоот тушаалаар мөрдөж эхэлсэн бөгөөд тайлант онд өөрчлөлт ороогүй байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн боловч стандартын өөрчлөлт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох шинэчлэгдсэн заавар, журамд нийцүүлэн өөрчлөх шаардлагатай байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд 9 дүүргийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг 3, амаржих газар 3, Нийслэлийн Эрүүл мэндийн газар /НЭМГ/, Нийслэлийн түргэн тусламжийн төв /НТТТ/, "Энэрэл" эмнэлэг, Наркологийн эмнэлэг, Шүд, эрүү, нүүрний төв /ШЭНТ/, Нийслэлийн ЗООНОЗ өвчин судлалын төв /НЗӨСТ/, Уламжлалт анагаах ухаан элэг судлалын клиник төв /УАУЭСКТ/, нийт 22 эрүүл мэндийн

байгууллагуудад ашиглагдаж байгаа програмын үйл ажиллагаатай танилцаж, асуулга явуулж, түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах ажиллагааг Сангийн яамны "Этайлан" програмаар боловсруулан санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргасан байна.

**Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:**

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар тус газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дүгнэлт өгөх үүднээс байгууллагын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжуууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар хяналтын горим 7, нарийвчилсан сорил 7-ийг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөн ажилласан байна.

Тус газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

**Дотоод хяналт:**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад санхүүгийн зарим үйл ажиллагаанд дотоод хяналт хангалтгүй байна.

**Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:**

2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу нийслэл, дүүргийн төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын нэр төрлөөр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Нийслэлийн Эрүүл мэндийн газар болон харъяа эрүүл мэндийн байгууллагуудад 2016 онд улсын төсвөөс 40 392 132.0 мянга, эрүүл мэндийн даатгалын сангаас 39 622 627.6 мянга, төсөвт байгууллагуудын өөрийн орлогоор 2 250 735.1 мянга, үндсэн бус үйл ажиллагааны орлогоор 81 233.0 мянга, нийт 82 346 727.7 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсан. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 39 433 094.1 мянга, эрүүл мэндийн даатгалын сангаас 39 254 597.4 мянга, үндсэн үйл ажиллагаанаас 1 870 756.1 мянга, үндсэн бус үйл ажиллагаанаас 125 283.8 мянга, нийт 80 683 731.4 мянган төгрөгийн орлого орж, төлөвлөгөөг 1 662 996.3 мянган төгрөг буюу 2.1 хувиар дутуу бүрдүүлжээ.

Тайлант онд үйл ажиллагааны зардалд нийт 82 346 727.7 мянган төгрөг зарцуулахаар батлагдсан. Гүйцэтгэлээр үйл ажиллагааны зардалд 80 682 381.5 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 1 147 334.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн. Батлагдсан төсвийг нийт 1 664 346.2 мянган төгрөг буюу 2.1 хувиар дутуу зарцуулсан.

Нэмэлт санхүүжилтийн дансаар нийт 3,625,470.1 мянган төгрөгийн орлого орсноос, 3,594,318.9 мянган төгрөгийг зарцуулж, 51,451.5 мянган төгрөгийн үлдэгдлийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

**Шилэн дансны мэдээлэл:**

Шилэн дансны тухай хуулийн дагуу тус байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн shilendans.gov.mn цахим хуудсанд 2016 оны төсвийн хуваарь, түүний гүйцэтгэл, санхүүгийн тайлан, дараа жилийн төсвийн төсөл, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ зэрэг мэдээллийг байршуулсан эсэхэд 2016 оны 4, 10 дугаар саруудад нийцлийн аудит хийгдсэн болно.

**Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:**

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 7 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 10 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Санхүүгийн үр дүнгийн болон мөнгөн гүйлгээний тайланд орлого, зарлагыг илүү тайлагнасан, үнэ төлбөргүй авсан хөрөнгийг үр дүнгийн тайланд ангилал зөрүүтэй, анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн, төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулсан, бараа материалыг дутуу тоолсон, хөрөнгийн ангиллыг зөрүүтэй

бүртгэсэн зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн хэмжилт, үнэлгээ, иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Эдгээр зөрчлүүд нь төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулах, төсвийн зориулалтыг зөрчих, хөрөнгө дутагдах, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй байх зэрэг сөрөг үр дагаварт хүрч болзошгүй байна.

**Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:**

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний нийт 48 131 757.2 мянган төгрөгийн /мөнгөн хөрөнгө, үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны орлого, үндсэн хөрөнгө, бараа материал, цалин хөлс/ ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалж нийт орлогын 66.4 хувь, нийт зардлын 50.3 хувь, нийт хөрөнгийн 60.7 хувийг тус тус эзэлж байна.

**Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:**

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараахь заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад **материаллаг** хэмжээний нийт 1 281 971.2 мянган төгрөгийн алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Санхүүгийн нэгтгэсэн тайланд “Амгалан” амаржих газар мөнгөн гүйлгээний тайланг 7 238.0 мянган төгрөгөөр зөрүүтэй нэгтгэсэн. Сангийн сайдын 2006 оны "Төсөв байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн аргачлал, заавар"-ын 3.2 заалтыг хэрэгжүүлээгүй.
   Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

2. Санхүүгийн байдлын тайланд НД-ийн ЭМН нь үндсэн хөрөнгийг 29 402.8 мянга, санхүүгийн үр дүнгийн тайланд Наркологи эмнэлэг үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг 44 797.9 мянга, мөнгөн гүйлгээний тайланд эхний үлдэгдлийг БЗД-ийн ЭМН нь 376.0 мянга, ШЭНТөв 332.4 мянга, “Амгалан” амаржих газар орлогыг 34.1 мянга, төсвийн гүйцэтгэлийн тайланд СХД-ийн ЭМН төсвийн гүйцэтгэлийн тайлангийн тохируулгыг 470.5 мянга, “Амгалан” амаржих газар 4 038.6 мянга, БЗД-ийн ЭМН 75.5 мянган төгрөгөөр зөрүүтэй, НД-ийн ЭМН 53 996.4 мянган төгрөгөөр нийгмийн даатгалын сангаас орж ирсэн тэтгэмжийн зардлыг илүү тайлагнасан. Эдгээр зөрчлүүд нь Сангийн сайдын 2006 оны "Төсөв байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн аргачлал, заавар"-ын 3.2 дахь заалтыг хэрэгжүүлээгүй.
   Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

3. СБД-ийн Нэгдсэн эмнэлэг 17,155.0 мянган төгрөгийн орлогыг дутуу тайлагнасан /өөрөөний 1 сарын орлогоор тооцоо хийхэд нийт 17 910.0 мянган төгрөгийн орлого орох тооцоо гарсан боловч 755.0 мянган төгрөгийн орлого орсон/ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүллээ.

4. Өмнөх оны аудитаар УАУЭСКТөв нь *|Богд- Уул сувилалын газрын 2 833 050.0 мянган төгрөгийн барилга|* барилгын үнийг давхардуулан бүртгэсэн зөрчлийг арилгаж, холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх албан шаардлага өгснийг хэрэгжүүлээгүй. НЭМГ болон УАУЭСКТөв НӨХГ-т уг хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх талаар албан бичиг хүргүүлсэн боловч одоо болтол шийдвэрлээгүй. Уг давхардуулан бүртгэсэн хөрөнгөнд нийт 47 217.5 мянган төгрөгийн элэгдэл байгуулж, зардалд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4. заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүллээ.

5. Үндсэн хөрөнгийн ангиллыг 72 535.0 мянган төгрөгөөр буруу бүртгэсэн нь Сангийн сайдын 2006 оны "Төсөв байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн аргачлал, заавар"-ын 4.30, УСНББОУС-17 холбогдох заалтыг хэрэгжүүлээгүй. /СХД-ийн ЭМН 14 470.7 мянга, "Өргөө амаржих" газар 11 997.1 мянга, СБД-ийн Нэгдсэн эмнэлэг 46 067.2 мянга/

Шийдвэрлэсэн: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүллээ.

6. СХД-ийн ЭМН-ийн 16 018.0 мянган төгрөгийн 2 ширхэг /агуулахын болон улаан булан гэсэн нэртэй/ барилга өөрийн хашаанд байхгүй, хүүхдийн хэсгийн хуучин барилгыг хувь хүмүүст гэрчилгээ гаргуулан ашиглуулж байгаа нь хөрөнгийн хадгалалт, хамгаалалтанд тавих хяналт хангалтгүй, хөрөнгө үрэгдэж алга болох эрсдэлтэй байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүллээ.

7. СБД-ийн ЭМН-ийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй "Мицубиши" маркийн /рентгенгийн зориулалттай/ автомашин ашиглагдахгүй, хувь хүний хашаанд байгаа нь хөрөнгийн хадгалалт, хамгаалалтанд тавих өдөр тутмын хяналт хангалтгүй. Дээрх зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх заалтыг хэрэгжүүлээгүй.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүллээ.

8. СБД-ийн Нэгдсэн эмнэлэг 17 754.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг санхүүгийн тайланд тусгаагүй, менежментийн багаас оруулсан хөрөнгө оруулалтаар хийгдсэн хөрөнгүүдийг данс бүртгэлд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4. заалтыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүллээ.

9. НЭМГ нь Зооноз, шинэ сэргэж буй гоц халдварт өвчний тусламж хариуцсан

мэргэжилтэнд 1 жилийн хугацаатай цалинтай чөлөө өгснөөс 3 114.0 мянган төгрөгийн цалинг илүү олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 23.3, 23.3.2. дахь заалтуудыг тус тус зөрчсөн.

Шийдвэрлэсэн: Нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоосон.

10. Зарим эрүүл мэндийн байгууллагууд ажилтнуудад нийт 27 084.2 мянган төгрөгийн ур чадвар болон бусад нэмэгдэл олгосон нь Төсвийн тухай хуулийн 6.4.1. дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 31.2 дахь заалт, 31.3. дахь заалт, Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт, "Төрийн албан хаагчид эрдмийн зэрэг, цолны нэмэгдэл олгох журам"-ын 2.4, Хөдөлмөрийн дотоод журмын 8.4 дахь заалтуудыг тус тус зөрчсөн. */Нийслэлийн түргэн тусламжийн төв 24 228.0 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл, СБД-ийн ЭМН нэмэгдэл eglny 1 975.4 мянга, Наркологийн эмнэлэг нэмэгдэл цалинд 880.8 мянга/*

Шийдвэрлэсэн: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

11. Зарим байгууллагууд ажилтнуудын ээлжийн амралтын цалинг бодохдоо хоол, унааны хөнгөлөлтийг дундаж цалинд оруулж тооцсоноос нийт 7 707.8 мянган төгрөгийн цалинг илүү олгосон нь Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны “Ээлжийн амралт тооцох журам”-ын 3 дахь заалт, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2005 оны “Дундаж цалин хөлс тодорхойлох журам“-ын 4.дэх заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй байна. /ШЭНТөв 7 337.3 мянга, БЗД-ийн ЭМН 370.5 мянга/

Шийдвэрлэсэн: Нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

12. “Амгалан” амаржих газар захиргаа, аж ахуйн 21 ажилтанд 5, 11 сард илүү цагаар ажилласны цалин 5 571.4 мянган төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6.4.1. дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

13. СБД-ийн Нэгдсэн эмнэлэг хэвтэн эмчлүүлэгчдийн хоолын материалыг бэлтгэхдээ сонгон шалгаруулалтгүй "Тэнгэр алтайн ивээл" ХХК-тай 161 886.0 мянган төгрөгийн шууд гэрээ байгуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6.1 дахь заалт, 8.2 дахь заалт, Засгийн газрын 2013 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 68 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өглөө.

14. Анхан шатны бүрдэлт дутуу баримтаар нийт 25 434.5 мянган төгрөгийг бараа материалыг зарцуулж, зардалд бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалтыг зөрчсөн. /УАУЭСКТөв 19 045.0 мянга, ХУД-ийн ЭМН 4 573.4 мянга, БЗД-ийн ЭМН 166.0 мянга, ХУД ЭМН 1 650.1 мянга/

Шийдвэрлэсэн: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн.

15. Жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор нийт 19 666.4 мянган төгрөгийн бараа материалыг тооллогод хамруулаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1 дэх заалтыг зөрчсөн. /Багануур дүүргийн

ЗООНЗ-ын өвчин судлалын төв 4 745.0 мянга, УАУЭСКТөв 32.9 мянга, Нийслэлийн түргэн тусламжийн төв 14 888.5 мянга/

Шийдвэрлэсэн: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өглөө.

16. Бараа материалын дансанд нийт 45 371.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэсэн нь Сангийн сайдын 2006 оны "Төсөв байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн аргачлал, заавар"-ын 4.16. "Бараа материалыг ангилж бүртгэхдээ дансны нэгдсэн жагсаалт болон холбогдох УСНББОУС-ыг мөрдөнө." заалтыг хэрэгжүүлээгүй. /БЗД-ийн ЭМН 9 081.9 мянга, ХУД-ын Нэгдсэн эмнэлэг 36 289.5 мянга/

Шийдвэрлэсэн: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

17. НЭМГ хөрөнгө оруулалтын урьдчилгаа төлбөрийн 657 800.0 мянган төгрөгийг урьдчилгаа дансаар дамжуулаагүй, бараа, ажил үйлчилгээний 16 893.3 мянган төгрөгийг тооцооны дансаар дамжуулахгүй зардалд шууд бүртгэсэн нь Сангийн сайдын 2006 оны "Төсөв байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн аргачлал, заавар"-ын 4.27 дахь заалтыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

**Материаллаг бус** хэмжээний 39 458.2 мянган төгрөгийн дараахь зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. "Амгалан" амаржих газар 6 111.0 мянган төгрөгийн бараа материалыг шууд зардалд бүртгэсэн нь Сангийн сайдын 2006 оны "Төсөв байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн аргачлал, заавар"-ын 4.21 дэх заалтыг хэрэгжүүлээгүй байна.

   Шийдвэрлэсэн: Зөрчлийг таслан зогсоох давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. УАУЭСКТөв бэлнээр орсон өөрийн орлогыг төрийн сангийн харилцах дансанд төвлөрүүлдэггүй, санхүүгийн тайланд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, Сангийн сайдын 2012 оны "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 2.6 дахь заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй.

   Шийдвэрлэсэн: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өглөө

3. "Амгалан" амаржих газар өмнөх онд үүссэн 3 133.8 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй, тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5. дахь заалтуудыг тус тус зөрчсөн.

   Шийдвэрлэсэн: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өглөө.

4. НЭМГ өмнөх оны НДШ-ийн 1 582.8 мянган төгрөгийн илүү төлөлтийг санхүүгийн тайланд тусгаагүй, залруулгыг буруу хийсэн, төлбөрийн актны 1 664.7 мянган төгрөгийг хүмүүсээс авч, төсөвт төлөх дансны бичилтийг буруу хийсэн нь

Сангийн сайдын 2006 оны "Төсөв байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн аргачлал, заавар"-ын 4.11, 4.61 дэх заалтыг хэрэгжүүлээгүй.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

5. Нийслэлийн түргэн тусламжийн төв нь ажилчдаас авах 1 220.8 мянган төгрөгийн авлагыг, "Хүрээ" амаржих газар өмнөх оны ажилтнуудад өгөх 3 306.6 мянган төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4. дэх заалтыг хэрэгжүүлээгүй.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

6. СБД-ийн ЭМН дүүргийн зохион байгуулсан тэмцээн болон ҮЭ-ийн хорооны урлагийн наадамд оролцсон ажилтнуудад нийт 4 359.8 мянган төгрөгийн шагнал, урамшуулал олгосон. Төсвийн тухай хуулийн 6.4.1, УИХ-ын 2016 оны 47 дугаар тогтоолын 5 дахь заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өглөө.

7. УАУЭСКТөв 2015 оны 15 888.1 мянган төгрөгийн илүү цагийн мөнгийг өглөгөөр бүртгээгүй, тайлант оны зардлаар бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1 дэх заалтыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

8. НД-ийн ЭМН сонгон шалгаруулалтгүйгээр хувь хүнээс 1 925.2 мянган төгрөгийн эмийн материал авсан, бараа материалын дансанд бүртгээгүй, шууд зардлаар тайлагнасан нь Сангийн сайдын 2006 оны "Төсөв байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн аргачлал, заавар"-ын 3.10.а дахь заалтыг хэрэгжүүлээгүй.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

9. СБД-ийн ЭМН нь B,C вирусын идэвхижил үзэх зориулалтаар ашиглуулж байгаа өрөөнөөс 265.4 мянган төгрөгийн түрээсийн төлбөрийг дутуу төвлөрүүлсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 5 дахь заалтыг хэрэгжүүлээгүй.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

10. СБД-ийн Нэгдсэн эмнэлэг нь удирдах албан тушаалтны цалинг менежментийн гэрээнд тусгасан хэмжээнээс илүү тогтоосон, нэмэгдэл цалин, шагнал урамшууллыг удирдах дээд байгууллагын /УЗ-ийн/ тогтоол, шийдвэргүй олгож байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

**Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:**

Хууль, журам, заавар мөрдөөгүйгээс шалтгаалан гарсан материаллаг болон материаллаг бус нийт 502,726.4 мянган төгрөгийн алдааг залруулах боломжгүй байна.

**Анхаарал татахуйц бусад чухал асуудал:**

НЭМГ нь нийслэлийн хэмжээний 2 дугаар шатлалын эмнэлгүүдийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэн гаргаж байгаа боловч тэдгээр байгууллагуудын төсвийг захирах ямар нэг эрх үүрэггүй юм.

Цалин хөлсийг урамшуулал, илүү цаг, нэмэгдэл үр дүн нэрээр харилцан адилгүй олгож байгаа нь Төрийн албаны тухай хуулийн 28.4 *"Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээ, жишгийг тогтоохад дараахь шаардлагыг харгалзан үзнэ"*, *28.4.1 "төрийн адил албан тушаалд адил хэмжээний цалин хөлс тогтоох"* заалтыг баримтлахгүй байна.

Үйлдвэрчний эвлэлийн татвар нэрээр ажилчдын цалингаас шууд суутган шилжүүлсэн боловч нэгтгэсэн өглөгийн дансаар тайлагнаагүй /40.0 тэрбумаас 1 хувиар тооцоход 400.0 орчим сая төгрөг/ байна. Түүнчлэн энэ нь Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийн 3.1. *"Иргэд хөдөлмөрлөх эрхээ хэрэгжүүлэх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах зорилгоор аливаа зөвшөөрөл авалгүй, гагцхүү өөрсдийн сайн дурын үндсэн дээр ямар нэг ялгаваргүйгээр үйлдвэрчний эвлэлд чөлөөтэй эвлэлдэн нэгдэх эрхтэй. 2.Үйлдвэрчний эвлэлд гишүүнээр элсэх буюу гишүүнээс гарахыг тулган шаардаж болохгүй."* заалттай нийцэхээргүй байгааг эргэн харах хэрэгтэй юм.

Өөрийн орлого нэрээр төрийн өмчийн байр ашиглан олсон орлогын 40 хүртэл хувиар шагнал, урамшууллыг тооцон олгож буй нь хууль тогтоомжид нийцэхгүй байна.

**Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:**

Уг асуудал нь аудитын хамрах хүрээний асуудал боловч цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эм бэлдмэлийн зардал, төлбөрт үйлчилгэний болон эрүүл мэндийн даатгалын сангаас олгож байгаа орлогуудыг 2017 оны завсрын аудитаар нөхөн шалгах болно.

**Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл**:

Нийслэлийн эрүүл мэндийн газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 1,321,429.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 818,703.0 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, 226,162.9 мянган төгрөгийн зөрчилд арилгах албан шаардлага, 10,821.8 мянган төгрөгийг төлбөр нөхөн төлүүлэх акт тогтоож, 265,741.7 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

**Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:**

Төсвийн захирагчийн төсвийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар 16 зөвлөмж өгснийг 12 зөвлөмжийг хэрэгжүүлж, 4 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

- НЭМГ-ын санхүүгийн нэгтгэсэн тайланд байгууллагуудын аудитлагдсан санхүүгийн тайлангуудыг үнэн зөв нэгтгэж байх;
- Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулан, барагдуулах арга хэмжээ авах;
- Анхан шатны баримтын бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах;
- Хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, заавар журмын дагуу чанартай хийх;

**Хязгаарлалттай санал дүгнэлт**

Дээрх алдаа, зөрчлийг эс тооцвол Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан 8 хуудас, менежментийн захидал 14 хуудас, байгууллагын санал 3 хуудсыг тус тус хавсаргав.

## АУДИТЫН ТАЙЛАНГ

**ХЯНАСАН:**

| | | |
|---|---|---|
| ДЭД ДАРГА | | С.ЭНХБААТАР |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | | А.ЦОГБАЯР |

**БЭЛТГЭСЭН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ҮI БАГИЙН

| | | |
|---|---|---|
| АХЛАХ АУДИТОР | | Х.ОЮУНЧИМЭГ |
| АХЛАХ АУДИТОР | | Ц.БАТСҮХ |
| АУДИТОР | | Д.НАРАНТУЯА |
| ШИНЖЭЭЧ | | Ч.ТҮВШИНСАЙХАН |

2017 оны 3 дугаар сарын 25

## Байгууллагаас ирүүлсэн хариу

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо
Бага тойруу-3, Ц.Жигжиджавын гудамж-9
Нийслэлийн засаг захиргааны II байр, Жанлавын ордон
Утас/Факс: (976-11) 32-50-76
E-mail: ubhd@emg.ub.gov.mn, http://www.ubhealth.mn

2017.03.24 № 1/300
танай __________ -ны № __________ -т

НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗАРТ

С. Энхбаатар
III/24

Менежментийн захидал хүргүүлэх тухай

Танай 2017 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 766 дугаар албан тоотоор ирүүлсэн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайланд баталгаажуулах аудит хийсэн "Менежментийн захидал"тай танилцлаа.

Сүхбаатар нэгдсэн эмнэлэг 17,550.0 мянган төгрөгийн орлого дутуу тайлагнаж, 161,886.0 мянган төгрөгийн шууд гэрээ байгуулсан, 17,754,5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг санхүүгийн тайланд тусгаагүй зэрэг зөрчлийг дахин гаргахгүй ажиллахыг шаардаж холбогдох арга хэмжээг авна.

Уламжлалт анагаах ухаан элэг судлалын клиникийн төв нь бэлнээр орсон өөрийн орлогыг төрийн сангийн харилцах дансанд төвлөрүүлдэггүй, санхүүгийн тайланд тусгаагүй зөрчилд арга хэмжээ авч ажиллах болно.

Өмнөх аудитаар УАУЭСКТөвийн Богд-Уул сувиллын 2,833,050.0 мянган төгрөгийн барилгын үнийг давхардуулан бүртгэсэн зөрчлийг арилгуулахаар Нийслэлийн Өмчийн харилцааны газарт хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэхээр албан бичгээр хандахад УАУЭСКТөвийн Менежментийн багаас асуудлыг хүлээн авах боломжгүй гэсэн хариуг албан тоотоор хүргүүлсэн байна.

Зарим байгууллагууд ур чадварын нэмэгдэл, шагнал, урамшууллыг хавтгайруулан олгосон, ээлжийн амралтын цалинг бодохдоо хоол, унааны хөнгөлөлтийг дундаж цалинд оруулж тооцсон, профессорын нэмэгдэлд олгосон, удирдах албан тушаалтны цалинг менежментийн гэрээнд тусгасан хэмжээнээс илүү тогтоосон зэрэг зөрчил гаргасан байгууллагуудад шаардлага тавьж холбогдох арга хэмжээг авна.

Дээрх зөрчил дутагдлыг гаргасан холбогдох байгууллагын дарга, нягтлан бодогч нарт Аудитын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу зохих арга хэмжээг авч ажиллах болно.

Хавсралт 3 хуудас

ДАРГА Л.ТӨМӨРБААТАР

1150560131

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР

2016.06.24 № 7/4408

огноо дугаар №

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАРТ

Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төвийн балансад Богд уул сувиллын 2833050.0 мянган төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий барилгыг давхар бүртгэснийг залруулж өгөхийг хүссэн танай 2015 оны 1/1236 тоот албан бичигтэй танилцлаа.

Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төвд дээрх хүсэлтийг уламжилж, залруулга хийх тухай албан бичиг ирүүлэх шаардлагыг манай газраас тавьсан боловч тус төвөөс 2015.12.15-ны өдөр 92 дугаар албан бичгээр асуудлыг хүлээн авах боломжгүй гэсэн хариу ирүүлсэн болно.

Албан бичгийн хуулбарыг хавсаргав.

Хавсралт 2 хуудастай.

ДАРГА Ш.ТӨМӨРБААТАР

1150500

УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ
ЭЛЭГ СУДЛАЛЫН КЛИНИК ТӨВ
18031 Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг
15 дугаар хороо, 1 дүгээр хороолол
Утас: 7018-1065, 7018-1176
http://www.uauesktov.mn

2015.12.15 № 92

танай ______ -ны №

НИЙСЛЭЛИЙН ӨМЧ ХАРИЛЦААНЫ
ГАЗРЫН ОРЛОГЧ ДАРГА Т.БАТДОРЖ
ТАНАА

Хүсэлт гаргаж, тайлбар
хүргүүлэх тухай

Тус Клиник төв нь Монгол Улсын Их хурлын 56, Засгийн газрын 34-р тогтоол, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 65, 46-р зүйл заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 128, 61, Нийслэлийн өмч хувьчлалын комиссын 54, 60, 73 тоот тогтоолуудын дагуу "Нэмэлт хөрөнгө оруулалт хийх нөхцөлтэйгээр менежментийн үр дүнг харгалзан хувьчлах" Гэрээг Нийслэлийн засаг даргын тамгын газрын Өмчийн харилцааны газартай 2008 оны 09 сарын 08-ны өдрөөс 2011 оны 09 сарын 08 хүртэл 3 жилийн хугацаатай байгуулан ажиллаж, Гэрээгээ дүгнүүлж дууссанаас хойш дуусгавар болгох шийдвэр гарахгүй өнөөг хүртэл 3 жил гаруй болж байна.

ТБОНӨХТХуулийн 35.1-д заасны дагуу уг хуулийн 37,70-р зүйлийн заалтуудыг үндэслэн Үнэлгээний байгууллага тооллого, үнэлгээг явуулж, ***Үндсэн хөрөнгийг 985.9 сая төгрөгөөр үнэлж, элэгдэл хорогдлыг хасаж, худалдан авах үнийг 870.011.000 төгрөгөөр тогтоож, НӨХКомиссын 73-р тогтоолоор "Худалдах" үнийг тогтоож, нээлттэй сонгон шалгаруулалтанд зарлагдаж, ялагчийг сонгон шалгаруулж Гэрээ байгуулсан болно.***

Иймээс 2008 оноос эхлэн ЭСКТөв нь ТБОНӨХТХууль болон Менежментийн Гэрээний дагуу ***"Дахин үнэлэх, үнэлгээг өөрчлөх зэрэг үйлдлийг хийхгүй байхыг хуулиар заасан"*** байтал СХДүүргийн өмчийн газраас мэргэжилтэн ирж, Эмнэлэгт дахин үнэлгээ хийх тухай удаа дараа мэдэгдэхэд нь манай зүгээс тухайн үед нь ТБОНӨХТХуулийн 35.1, 35.3, 36.4, 37.1 дэх заалтуудын дагуу Менежментийн хувьчлал хийгдэж байгаа байгууллагад *"дахин үнэлгээнд хамруулах нь"* хууль зөрчсөн үйлдэл болохыг дурдаж албан тоотоор мэдэгдсэн.

Гэвч СХДүүргээс мэргэжилтэн ирж, өөрсдөө дахин үнэлгээг хийсэн нь туйлын үндэслэл муутай, бодит байдлаас хол үнэлгээ байсан. Үүнээс зөвхөн зарим нэгийг дурдахад: байгууллагын аж ахуйн модон хашааг 441 сая төгрөгөөр үнэлсэн мөн Сувилал эмчилгээний барилгыг 1959 онд баригдсан, мөн 2004 онд баригдсан гэх мэтээр нэг барилгыг хоёр дахин [illegible] 2.833.050.000 (хоёр тэрбум

найман зуун гучин гурван сая тавин мянган төгрөг/ үнэлэх зэргээр үнийг **"Хэт хөөрөгдөж, үндэслэлгүй хийгдсэн дахин үнэлгээгээр эмнэлгийн үнэлгээ 6.613.342.097.00** /зургаан тэрбум зургаан зуун арван гурван сая гурван зуун дөчин хоёр мянга ерэн долоон төгрөг/" болсон байгаа. Гэтэл НӨХГазраас "Тэрхүү бодит бус үнэлгээг залруулах хүсэлтийг танайх гаргах хэрэгтэй байна. бид эндээ засаж залруулна" гэж 2015 оны 12-р сарын 14-нд буюу өчигдөр мэдэгдсэн болно.

Бид Монгол улсад мөрдөгдөж байгаа ТБОНӨХТХууль болон Гэрээний заалтын дагуу Менежментийн хувьчлал явагдаж байх үед *"Дахин үнэлгээ хийсэн болон хуудуутай үнэлгээний дүн зэргийг хүлээн авах нь хоёр талдаа хууль зөрчсөн үйлдэл болно"* гэж үзэж байгаа тул уг асуудлыг хүлээн авах боломжгүй байгаагаа үүгээр уламжилж байна.

***Менежментийн Гэрээний 12.1.4 дэх заалтанд: "НӨХКомиссын хуралдаанаас Менежментийн гэрээний үүрэг биелэгдсэн гэж үзвэл дуусгавар болгох тухай шийдвэр гаргаж, худалдагчийн болон худалдан авагчийн төлөөлөгчид менежментийн гэрээ дуусгавар болсон тухай баримтанд гарын үсэг зурна"*** гэж тодорхой заасан

Иймд Эрхэм Танд Захиргааны хэргийн гурван шатны шийдвэрээр "НӨХКомисст Менежментийн Гэрээний 12.1.4-т заасны дагуу уг эмнэлгийн менежментийн хувьчлалыг дуусгавар болгохыг даалгасан" Шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, дуусгавар болгож өгөхийг хичээнгүйлэн уламжилж байна.

***Жич: Дээр дурдсандчилан үл ойлгогдох асуудал мөн Менежментийн хувьчлалтай холбоотой аливаа асуудал гарвал тодруулга өгөх зорилгоор Менежментийн баг Гэрээний 12.1.3-т заагдсан эрхийнхээ дагуу НӨХКомиссын хуралд биечлэн оролцох хүсэлтэй байгаагаа Танд уламжлахын зэрэгцээ, НӨХКомиссын гишүүдэд.албан ёсоор танилцуулж өгөхийг хичээнгүйлэн хүсье.***

Таныг хүндэтгэн ёсолсон

МЭРГЭЖЛИЙН БАГИЙН АХЛАГЧ — Ж. ХАТАНБААТАР
Монгол Улсын Ардын эмч
АУ-ны доктор, Профессор

НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР
НАГ АОСС
AUDIT OFFICE OF CAPITAL CITY

# НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

## Менежментийн захидал

**Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:**

Асуудал 1
Санхүүгийн тайлан нэгтгэлийн талаар ........ 3

Асуудал 2
Санхүүгийн тайлагнал ........ 4

Асуудал 3
Орлогын бүртгэл ........ 4-5

Асуудал 4
Мөнгөн хөрөнгө ........ 5-6

Асуудал 5
Авлага ........ 7

Асуудал 6
Бараа материал ........ 8-9

Асуудал 7
Үндсэн хөрөнгө ........ 9-10

Асуудал 8
Өр төлбөр ........ 10-11

Асуудал 9
Цалин хөлс ........ 11-14

**Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:**

Асуудал 1
Зардал ........ 15

Асуудал 2
Нягтлан бодох бүртгэл, дотоод хяналт ........ 16

2017 оны 03 дугаар сар 23

## Менежментийн захидал

Нийслэлийн Аудитын газар санхүүгийн тайлангийн аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн энэхүү менежментийн захидлыг Нийслэлийн Эрүүл мэндийн газрын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд дотоод хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өгч байна.

Менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг төрийн аудитын байгууллагын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Өгч байгаа аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа юм.

Нийслэлийн Аудитын газрын зөвлөмж та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлэх нь танай үүрэг мөн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Нийслэлийн Эрүүл мэндийн газар болон харъяа эрүүл мэндийн байгууллагуудын холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Асуудал 1: Санхүүгийн тайлангийн нэгтгэл**

**НАГ-ын ажиглалт:**

- Санхүүгийн нэгтгэсэн тайланд "Амгалан" амаржих газар мөнгөн гүйлгээний тайланг 7 238.0 мянган төгрөгөөр зөрүүтэй нэгтгэсэн. Сангийн сайдын 2006 оны "Төсөв байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн аргачлал, заавар"-ын 3.2 заалтыг хэрэгжүүлээгүй.

**Эрсдэлүүд**:

Санхүүгийн тайланг нэгтгэхдээ бүрэн, үнэн, зөв тайлагнаагүй байх;

**Тэргүүлэх ач холбогдол 1:**

**НАГ -ын зөвлөмж:**

Нэгтгэсэн тайланд байгууллагуудын аудитлагдсан санхүүгийн тайлангуудыг үнэн, зөв нэгтгэж байх;

**Төсвийн захирагчийн хариу**

**Асуудал 2: Санхүүгийн тайлагнал**

**НАГ-ын ажиглалт:**

Санхүүгийн байдлын тайланд НД-ийн ЭМН үндсэн хөрөнгийг 29 402.8 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.

- Санхүүгийн үр дүнгийн тайланд Наркологи эмнэлэг үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг 44 797.9 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.

- Мөнгөн гүйлгээний тайланд эхний үлдэгдлийг БЗД-ийн ЭМН нь 376.0 мянга, ШЭНТ 332.4 мянга, "Амгалан" амаржих газар орлогыг 34.1 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан.

- Төсвийн гүйцэтгэлийн тайланд СХД-ийн ЭМН тохируулгыг 500.0 мянга, "Амгалан" амаржих газар 4 038.6 мянган төгрөгөөр зөрүүтэй, БЗД-ийн ЭМН 75.5 мянга, НД-ийн ЭМН 53 996.4 мянган төгрөгийн нийгмийн даатгалын сангаас орж ирсэн тэтгэмжийн зардлыг тайлагнасан. Эдгээр зөрчлүүд нь Сангийн сайдын 2006 оны "Төсөв байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн аргачлал, заавар"-ын 3.2 дахь заалтыг хэрэгжүүлээгүй.

**Эрсдэлүүд**:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх;

Холбогдох хууль, тогтоомж, заавар журам хэрэгжихгүй байх

**Тэргүүлэх ач холбогдол 1:**

**НАГ-ын зөвлөмж:**

Санхүүгийн тайланг холбогдох заавар, журмын дагуу үнэн, зөв тайлагнаж байх;

Санхүүгийн үр дүнгийн болон мөнгөн гүйлгээний тайланд орлого, зарлагын ангиллыг холбогдох заавар, журмын дагуу үнэн зөв тайлагнаж байх;

Төсвийн гүйцэтгэлийн тайланг холбогдох заавар, журмын дагуу үнэн, зөв тайлагнаж байх;

**Төсвийн захирагчийн хариу**

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

**Асуудал 3: Орлогын бүртгэл**

**НАГ-ын ажиглалт:**

- СБД-ийн ЭМН В,С вирусын идэвхижил үзэх зориулалтаар ашиглуулж байгаа өрөөнөөс 265.4 мянган төгрөгийн түрээсийн төлбөрийг дутуу төвлөрүүлсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 5. "*Төрийн өмчийн түрээсийн төлбөрийг улсын төсөвт оруулна...*" заалтыг хэрэгжүүлээгүй.

- СБД-ийн Нэгдсэн эмнэлгийн төлбөртэй өрөөний 1 сарын орлогоор тооцоо хийхэд нийт 17 910.0 мянган төгрөгийн орлого орох тооцоо гарсан боловч 755.0 мянган төгрөгийн орлого орж, 17 155.0 мянган төгрөгийг дутуу тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1."*Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө.*" заалтыг зөрчсөн.

**Эрсдэлүүд**:

Санхүүгийн тайланд орлого дутуу тусгах илэрхийлэгдэх;

Холбогдох хууль, тогтоомж, заавар журам хэрэгжихгүй байх

**Тэргүүлэх ач холбогдол 1:**

**НАГ -ын зөвлөмж:**

Үйл ажиллагааны орлогыг холбогдох заавар журмын дагуу үнэн зөв тооцож, санхүүгийн тайланд үнэн, зөв тайлагнах;

**Төсвийн захирагчийн хариу**

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

**Асуудал 4: Мөнгөн хөрөнгө**

**НАГ-ын ажиглалт:**

УАУЭСКТөв бэлнээр орсон өөрийн орлогыг төрийн сангийн харилцах дансанд төвлөрүүлдэггүй, санхүүгийн тайланд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1. *"Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө."*, Сангийн сайдын 2012 оны "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 2.6. *"Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана"* заалтыг хэрэгжүүлээгүй.

**Тэргүүлэх ач холбогдол 1:**

**НАГ -ын зөвлөмж:**

Үйл ажиллагааны орлогыг төрийн сангийн дансанд хугацаанд нь төвлөрүүлж, санхүүгийн тайланд тусгаж байх;

- ХУД-ийн ЭМН анхан шатын бүрдэл дутуу баримтаар 1 650.1 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. *"Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно."* заалтыг зөрчсөн байна.

**Эрсдэлүүд**:

Санхүүгийн тайланд мөнгөн хөрөнгө зөрүүтэй илэрхийлэгдэх;

Холбогдох хууль, тогтоомж, заавар журам хэрэгжихгүй байх

Анхан шатны баримтын бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах;

**Төсвийн захирагчийн хариу**

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

**Асуудал 5: Авлага**

**Тэргүүлэх ач холбогдол 1:**

**НАГ-ын ажиглалт:**

- "Амгалан" амаржих газар өмнөх онд үүссэн 3 133.8 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй, тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6.4.8. *"төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх."* Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5. *"дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;"* заалтуудыг зөрчсөн.

